

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**  
**АГААРЫН НАВИГАЦИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

**“МОНГОЛЫН АГААРЫН НАВИГАЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ  
ХАНГАХ АЖЛЫН ХЭСЭГ”**



**“Нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвүүдийн хооронд өгөгдлийн холбооны үйлчилгээг зохицуулах ажлын баг” семинарын тайлан**

Улаанбаатар хот

2019.01.21

## **АГУУЛГА**

### **1. ТАНИЛЦУУЛГА**

#### **1.1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

#### **1.2 ЗОРИЛГО**

#### **1.3 ХУРЛЫН ТУХАЙ, ОРОЛЦСОН БҮРЭЛДЭХҮҮН**

### **2. ТАНИЛЦУУЛГА ИЛТГЭЛ**

### **3. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

### **4. ХУРЛААС ГАРСАН ШИЙДВЭРЛЭХ АСУУДЛУУД**

## **1. ТАНИЛЦУУЛГА**

### **1.1. Ерөнхий зүйл**

Монгол Улсын иргэний нисэхийн байгууллага нь Олон улсын иргэний нисэх байгууллага(ИКАО-)д 1989 онд элссэн. Тус байгууллага нь 8 бүсчлэл бүхий 191 гишүүн улстай бөгөөд Ази номхон далайн бүс (АРАС)-д 37 улс байдаг.

АРАНПИРГ буюу Ази-Номхон далайн орнуудын агаарын навигацийг төлөвлөх, хэрэгжүүлэх бүсийн ажлын хэсэг 1991 онд байгуулагдаж, анхны хуралдаанаа 1992 онд хийсэн.

Иргэний нисэхийн ерөнхий газар нь АРАНПИРГ/10 хурлаас хойш тус хурлын үйл ажиллагаанд оролцож ИКАО-гаас гаргасан “GANP”, “ASBU” болон “Seamless ATM” гэсэн бодлого төлөвлөгөөний дагуу Монгол Улсын агаарын навигацийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх ажлыг шат дараатай гүйцэтгэж байна.

Энэхүү ажлын хүрээнд Нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвүүдийн хооронд өгөгдлийн холбооны үйлчилгээг зохицуулах үйл ажиллагаа сэдэвт анхдугаар хурлыг зохион байгуулсан.

### **1.2. Зорилго**

Нислэгийн хөдөлгөөн удирдлагын төвүүдийн хооронд өгөгдөл солилцох талаар Монгол улс дахь өнөөгийн нөхцөл байдлыг үнэн бодитоор үнэлэх, цаашдын хөгжлийн чиг хандлагыг судлах, бодлого чиглэлийг оролцогч талуудад танилцуулах, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд оршино.

1.3 Нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвүүдийн өгөгдлийн холбооны үйлчилгээг зохицуулах анхдугаар хурлыг Иргэний нисэхийн ерөнхий газрын ИНЕГ-ийн хурлын танхимд 2019 оны 1 сарын 15-нд 15:00 цагаас 17:00 цагийн хооронд амжилттай зохион байгууллаа. Тус хуралд ИНЕГ-ын харьяа 7 албаны, 19 төлөөлөгч оролцлоо.

## **ХУРАЛД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД:**

- АГААРЫН НАВИГАЦИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
- НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА
- ХОЛБОО НАВИГАЦИ АЖИГЛАЛТЫН АЛБА
- НИСЛЭГИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА
- НИСЛЭГИЙН ЖУРАМ БОЛОВСРУУЛАЛТЫН АЛБА
- НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВ

## **2. ТАНИЛЦУУЛГА**

Нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвүүдийн өгөгдлийн холбооны үйлчилгээг зохицуулах багийн ахлагч ХНАА-ийн Ерөнхий инженер Х.Баттулга Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын Ази номхон далайн орнууд (APAC)-ийн хэмжээнд явагдаж байгаа Нислэгийн хөдөлгөөн удирдлагын төвүүдийн хооронд өгөгдөл солилцох ажлын хэрэгжилт гарч байгаа хүндрэлүүдийн талаар дурдаад танилцуулгыг хийв.

## **3. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

Хуралд оролцогсад Монгол улс дахь өнөөгийн нөхцөл байдлыг үнэн бодитоор үнэлэх, цаашдын хөгжлийн чиг хандлагыг судлах, баримталж буй бодлого чиглэлийн талаар хэлэлцүүлэг хийн, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх санал гаргав.

Хэлэлцүүлэгт хурлын гишүүд идэвхтэй оролцон өөрсдийн үзэл бодлоо солилцон дараах саналуудыг дэвшүүлж цаашид шийдвэрлэх шаардлагатай гэж үзэв.

Үүнд:

1. Улаанбаатар нислэгийн хөдөлгөөн удирдлагын төвийн автоматжуулсан системийн AIDC OLDI өргөтгөл хийгдсэн байдал, цаашдын боломж
2. БНХАУ ийн хил залгаа нислэгийн хөдөлгөөн удирдлагын төвүүдэд суурилагдсан автоматжуулсан системүүдийн төрөл, AIDC холбох боломжийн талаар үйлдвэрлэгчийн тайлбар судалгаа,
3. БНХАУ ийн AIDC хэрэгжүүлсэн тайлан болон хүндрэлүүд
4. Бээжин нислэгийн хөдөлгөөн удирдлагын төвтэй AFTN шугамаар AIDC холбох ажлын явц.
5. УБ нислэгийн хөдөлгөөн удирдлагын төвийн ATN -р AIDC мэдээлэл дамжих боломжийг судлан , туршилтыг гүйцэтгэх
6. Шинэ бүсийн нислэгийн хөдөлгөөн удирдлагын төв д суурилагдах Автоматжуулсан системийн Техникийн тодорхойлолтод AIDC: 20 messages, OLDI: 37 messages) бүх стандарт мэдээллийг AFTN, ATN, Dedicated line зэрэг шугамуудаар дамжуулах боломжтой байхаар тусгаж оруулах

7. Олон улсын хурал семинарт идэвхтэй оролцож олон улсын нислэгийн хөдөлгөөн удирдлагын төвүүдийн өгөгдөл солилцох үйл ажиллагаатай танилцаж гаднын сайн туршлагауудыг эх орондоо нутагшуулах.

#### **4. ХУРЛЫН ЗҮГЭЭС АГААРЫН НАВИГАЦИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР “ХОЛБОО НАВИГАЦИ АЖИГЛАЛТЫН ДЭД АЖЛЫН ХЭСГЭЭР ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДЛУУД**

1. Бээжин Нислэгийн хөдөлгөөн удирдлагын төвтэй AFTN шугамаар AIDC холбох ажлыг гүйцээн ажлын үр дүнг үнэлэн цаашдын ашиглалтыг тодорхойлох.
2. УБ нислэгийн хөдөлгөөн удирдлагын төвийн автоматжуулсан системийн AIDC мэдээллийг ATN -р дамжуулах боломжийг судлан , туршилтыг гүйцэтгэх
3. Шинэ бүсийн нислэгийн хөдөлгөөн удирдлагын төв д суурилагдах Автоматжуулсан системийн Техникийн тодорхойлолтод хөрш зэргэлдээ бүсийн төвүүдтэй (AIDC: 20 messages, OLDI: 37 messages) бүх стандарт мэдээллийг AFTN, ATN, Dedicated line зэрэг шугамуудаар дамжуулах боломжтой байхаар тусгаж оруулах
4. Олон улсын хурал семинарт идэвхтэй оролцож олон улсын нислэгийн хөдөлгөөн удирдлагын төвийн өгөгдөл солилцох үйл ажиллагаатай танилцаж гаднын сайн туршлагауудыг эх орондоо нутагшуулах.

Тайлан боловсруулсан: Багийн ахлагч

Х.Баттулга